

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/313/НА-СТА-ТШЗ

Цахим www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	хуудас:	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 261885 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Аудитор: Т.Нямсүрэн Утас: 261628. Цахим хаяг: nyamsurent@audit.gov.mn Эс Жи Эм Ди-Аудит ХХК-ийн захирал: Д.Насанжаргал Утас: 99996948 Цахим хаяг: nasaa@sgmd-audit.mn
---	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026. 02. 25 № 06/418
танай _____-ны № _____-т

ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ
МУЗЕЙН ЗАХИРАЛ Д. МӨНХЧУЛУУН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Чойжин ламын сүм музей нь 2025 оны 5 дугаар сарын 20-ноос 26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын "Гуружи" галерейд тус улсын уран бүтээлч Мира Юны гэрэл зургийн "Мандала" үзэсгэлэнг хамтран зохион байгуулан музейн сан хөмрөгийн 40 гаруй түүх, соёлын үнэт бүтээлийг дэлгэн үзүүлж, сурталчилсан байна. Дээрх арга хэмжээд 34,023.1 мянган төгрөгийг тийз болон томилолтын зардалд зарцуулсан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 цомцог гэрийг Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан холбогдох журам, зохицуулалтын дагуу түрээслүүлээгүй, тус хөрөнгийг бартерын гэрээ байгуулан ашиглуулсан бөгөөд ашиглалттай холбоотой зардлыг байгууллагын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Тайлант онд 910,353.6 мянган төгрөгийн орлого болон зарлагын дүнтэй төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэсэн боловч нийт дүнгээр, хөтөлбөрөөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн талаар иж бүрэн тайлагнаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152,353,449.61	233,068,611.07
33	АВЛАГА	4,500,000.00	129,835,600.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	4,500,000.00	4,005,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	125,830,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	147,853,449.61	103,233,011.07
351	Түүхий эд материал	15,564,511.00	22,275,511.00
35110	Тусгай зориулалттай материал	15,564,511.00	22,275,511.00
354	Хангамжийн материал	132,288,938.61	80,957,500.07
35410	Бичиг хэргийн материал	15,662,500.61	10,370,202.07
35420	Аж ахуйн материал	18,103,628.00	17,292,328.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,548,590.00	3,548,590.00
35470	Бусад хангамжийн материал	94,564,220.00	49,746,380.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,824,226,089.99	4,806,116,334.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,824,226,089.99	4,806,116,334.55
392	Биет хөрөнгө	4,149,626,089.99	4,131,516,334.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	341,312,404.90	341,312,404.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(157,246,871.49)	(169,778,708.97)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	350,581,748.97	405,563,748.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(225,378,402.97)	(272,728,495.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	155,100,548.00	155,100,548.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(55,597,918.62)	(66,898,954.34)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,728,012,966.00	3,728,012,966.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,961,652.52	45,961,652.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	(35,679,702.32)	(37,588,492.28)
39217	Ном	2,559,665.00	2,559,665.00
393	Биет бус хөрөнгө	674,600,000.00	674,600,000.00
39301	Програм хангамж	990,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(990,000.00)	(990,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	674,600,000.00	674,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,976,579,539.60	5,039,184,945.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,008,421.51	125,839,597.11
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,008,421.51	125,839,597.11
413	Өглөг	10,008,421.51	125,839,597.11
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,008,421.51	9,597.11
4136	Бусад өглөг	-	125,830,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	66,480,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	59,350,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	4,966,571,118.09	4,913,345,348.51
51	Засгийн газрын хувь оролцоо	4,966,571,118.09	4,913,345,348.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,906,414,021.00	1,906,414,021.00
51101	Өмч: - төрийн	1,906,414,021.00	1,906,414,021.00
512	Хуримтлагдсан үр дүн	523,748,460.35	470,522,690.77
51210	Өмнөх үеийн үр дүн	523,748,460.35	523,748,460.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	(53,225,769.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,536,408,636.74	2,536,408,636.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,976,579,539.60	5,039,184,945.62

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1,094,995,950.00	1,092,312,710.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,092,312,710.00
122	Тусламжийн орлого	-	1,092,312,710.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,092,312,710.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	849,248,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	849,248,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	243,064,610.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,120,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	229,944,610.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,094,995,950.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	877,683,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	877,683,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	217,312,750.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	202,312,750.00	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,094,995,950.00	1,092,312,710.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,115,979,177.88	1,145,538,479.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,115,979,177.88	1,145,538,479.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,031,967,995.40	1,022,724,500.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	544,448,974.84	543,848,279.81
210101	Үндсэн цалин	347,115,734.81	352,247,159.01
210102	Нэмэгдэл	98,714,021.53	105,505,865.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,230,000.00	32,915,505.46
210104	Урамшуулал	52,389,218.50	53,179,750.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,120,584.74	68,225,277.98
210201	Тэтгэврийн даатгал	47,187,712.39	46,965,406.08
210202	Тэтгэмжийн даатгал	5,161,878.71	5,236,059.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,791,596.84	2,933,662.47
210204	Ажилгүйдлийн даатгал	2,595,839.40	2,618,029.92
210205	Эрүүл мэндийн даатгал	10,383,557.40	10,472,119.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,419,365.79	21,305,375.76
210301	Гэрэл, цахилгаан	29,359,399.23	19,580,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,059,966.56	1,725,275.76
2104	Хангамж, бараа материалын зардал	47,563,721.87	95,068,002.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,239,116.16	2,809,063.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,019,000.00	3,641,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,844,605.71	88,617,938.54
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,371,225.00	156,825,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	169,573,225.00	150,325,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,298,000.00	1,500,000.00

**Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,044,123.16	137,452,564.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,338,381.42	17,628,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,665,670.00	46,732,809.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,040,071.74	73,091,755.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,011,182.48	122,813,979.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,567,900.00	89,486,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,662,900.00	19,073,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,412,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,905,000.00	51,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,443,282.48	33,327,679.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,124,879.48	32,952,378.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(20,983,227.88)	(53,225,769.58)
5	НИЙТ ҮР ДҮН	(20,983,227.88)	(53,225,769.58)

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,090,495,950.00	1,089,687,710.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,090,495,950.00	1,089,687,710.00
122	Тусламжийн орлого	-	1,089,687,710.00
1221	Хандив тусламжийн орлого (дотоод)	-	1,089,687,710.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	849,248,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	849,248,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	240,439,610.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	230,439,610.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,090,495,950.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	877,683,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	877,683,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	212,812,750.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	197,812,750.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	994,395,650.00	1,053,497,710.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	994,395,650.00	1,053,497,710.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	910,384,467.52	854,353,130.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	535,009,205.90	554,342,568.04
210101	Үндсэн цалин	336,403,669.65	352,247,159.01
210102	Нэмэгдэл	98,318,209.42	107,307,066.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,230,000.00	41,608,592.63
210104	Урамшуулал	54,057,326.83	53,179,750.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,514,462.67	67,729,814.15
210201	Тэтгэврийн даатгал	47,129,001.65	46,469,942.25
210202	Тэтгэмжийн даатгал	5,029,058.72	5,236,059.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,709,056.45	2,933,662.47
210204	Ажилгүйдлийн даатгал	2,529,429.40	2,618,029.92
210205	Эрүүл мэндийн даатгал	10,117,916.45	10,472,119.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,419,365.79	21,305,375.76
210301	Гэрэл, цахилгаан	29,359,399.23	19,580,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,059,966.56	1,725,275.76
2104	Хангамж, бараа материалын зардал	35,067,616.16	25,220,563.94
210401	Бичиг хэрэг	13,444,250.00	2,702,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,239,116.16	2,809,063.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,019,000.00	3,641,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,365,250.00	16,068,000.00

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	229,973,725.00	114,374,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	222,075,725.00	107,966,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,298,000.00	1,500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,600,000.00	4,908,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,665,670.00	71,380,809.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	24,648,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,665,670.00	46,732,809.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,011,182.48	199,144,579.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,567,900.00	39,986,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,662,900.00	19,073,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,412,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,905,000.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,443,282.48	159,158,279.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,124,879.48	32,952,378.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	96,100,300.00	36,190,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	96,100,300.00	36,190,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	96,100,300.00	36,190,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	96,100,300.00	36,190,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	96,100,300.00	36,190,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(96,100,300.00)	(36,190,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,906,414,021.00	2,536,408,636.74	544,731,688.23	4,989,210,151.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,906,414,021.00	2,536,408,636.74	544,731,688.23	5,095,898,633.53
Тайлант үеийн үр дүн	-	-	(20,983,227.88)	(20,983,227.88)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,906,414,021.00	2,536,408,636.74	523,748,460.35	4,987,554,345.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,906,414,021.00	2,536,408,636.74	523,748,460.35	4,987,554,345.97
Тайлант үеийн үр дүн	-	-	(53,225,769.58)	(53,225,769.58)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,906,414,021.00	2,536,408,636.74	470,522,690.77	4,913,345,348.51

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	883,883,400.00	816,295,721.89	67,587,678.11	92.35
12	Татварын бус орлого	883,883,400.00	816,295,721.89	67,587,678.11	92.35
122	Тусламжийн орлого	883,883,400.00	816,295,721.89	67,587,678.11	92.35
122005	Төсвөөс санхүүжих	883,883,400.00	816,295,721.89	67,587,678.11	92.35
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	883,883,400.00	816,295,721.89	67,587,678.11	92.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	883,883,400.00	816,295,721.89	67,587,678.11	92.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,397,100.00	777,809,421.89	67,587,678.11	92.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,236,400.00	554,342,568.04	13,893,831.96	97.55
210101	Үндсэн цалин	335,495,900.00	352,247,159.01	(16,751,259.01)	104.99
210102	Нэмэгдэл	96,306,200.00	107,307,066.40	(11,000,866.40)	111.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	79,105,400.00	41,608,592.63	37,496,807.37	52.60
210104	Урамшуулал	57,328,900.00	53,179,750.00	4,149,150.00	92.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,888,600.00	67,729,814.15	3,158,785.85	95.54
210201	Тэтгэврийн даатгал	48,870,900.00	46,469,942.25	2,400,957.75	95.09
210202	Тэтгэмжийн даатгал	5,501,400.00	5,236,059.84	265,340.16	95.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,762,700.00	2,933,662.47	(170,962.47)	106.19
210204	Ажилгүйдлийн даатгал	2,750,700.00	2,618,029.92	132,670.08	95.18
210205	Эрүүл мэндийн даатгал	11,002,900.00	10,472,119.67	530,780.33	95.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,420,600.00	21,305,375.76	1,115,224.24	95.03
210301	Гэрэл, цахилгаан	20,695,400.00	19,580,100.00	1,115,300.00	94.61
210303	Цэвэр, бохир ус	1,725,200.00	1,725,275.76	(75.76)	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,304,600.00	1,161,563.94	143,036.06	89.04
210401	Бичиг хэрэг	598,700.00	272,500.00	326,200.00	45.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	705,900.00	889,063.94	(183,163.94)	125.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,862,700.00	36,190,000.00	14,672,700.00	71.15
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,862,700.00	36,190,000.00	14,672,700.00	71.15
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,537,200.00	72,432,100.00	21,105,100.00	77.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,216,300.00	72,432,100.00	14,784,200.00	83.05
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,977,100.00	-	4,977,100.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,343,800.00	-	1,343,800.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,147,000.00	24,648,000.00	13,499,000.00	64.61

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,147,000.00	24,648,000.00	13,499,000.00	64.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,486,300.00	38,486,300.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,486,300.00	38,486,300.00	-	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,073,500.00	19,073,500.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,412,800.00	19,412,800.00	-	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	36	36	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	18	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	16	16	-	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	15	15	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	1	-	100.00
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1	1	-	100.00
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1	1	-	100.00

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	240,439,610.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	240,439,610.00
122	Тусламжийн орлого	240,439,610.00
1221	Хандив тусламж /дотоод/	240,439,610.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	240,439,610.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	230,439,610.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,282,770.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,282,770.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	114,233,709.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,059,000.00
210401	Бичиг хэрэг	2,430,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,641,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,068,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,941,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,533,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,908,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,732,809.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	46,732,809.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	126,205,901.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(126,205,901.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(126,205,901.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Чойжин ламын сүм музейн нь сан хөмрөгт хадгалагдаж буй Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт, үнэт үзмэр, дурсгалт барилга зэргийг тайлбарлан танилцуулах, сурталчлах чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг.

Чойжин ламын сүм музейн нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Музейд хадгалагдаж буй Монголын түүх, шашин, соёл, уран барилга, урлахуйн ухааны дахин давтагдашгүй үнэт бүтээлийг судлан сурталчилж, сэргээн баяжуулах, хадгалан хамгаалж, хойч үеийнхэнд уламжлуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Чойжин ламын сүм музейн нь Соёлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль болон Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”;
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус музей нь дотоод аудитын нэгж, ажилтангүй, соёлын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс дотоод аудитыг хийдэг бөгөөд 2025 оны III улирлын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62.6 сая төгрөгөөр буюу 1.26 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	4,500.0	129,835.6	125,335.6
Бараа материал	147,853.4	103,233.0	(44,620.4)
Үндсэн хөрөнгө	4,824,226.1	4,806,116.3	(18,109.8)
Нийт хөрөнгө	4,976,579.5	5,039,184.9	62,605.4
Өр төлбөр	10,008.4	125,839.6	115,831.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,966,571.1	4,913,345.3	(53,225.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,976,579.5	5,039,184.9	62,605.4

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна. Үүнд:

- Тайлант онд авлага дансны үлдэгдэл 129,835.6 мянган төгрөг болсон нь үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг улсын төсөвт төвлөрүүлснээс авах авлага 125,830.6 мянган төгрөг, харилцагч гэрээт жуулчны компаниудаас авах ваучерын авлага 4,005.0 мянган төгрөгийн авлагуудыг бүртгэсэнтэй холбоотой байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 103,233.0 мянган төгрөг болж, 44,620.4 мянган төгрөгөөр буурсан нь тайланд 43,997.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч данс бүртгэлд тусган, 88,617.9 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,806,116.3 мянган төгрөг болж, 18,109.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 54,982.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан бөгөөд үүнтэй холбоотой байгуулсан элэгдлийн зардал болох 73,091.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцсоноос шалтгаалсан.
- Өглөг дансны үлдэгдэл 125,839.6 мянган төгрөг болсон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг улсын төсөвт татан төвлөрүүлэн зарцуулах эрх олгоогүйн улмаас байгууллага болон хувь хүмүүст төлөх 125,830.0 мянган төгрөгийн, НДШ-д төлөх 9.6 мянган төгрөгийн өглөгийг тус тус төлөөгүйтэй холбоотой.
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 4,913,345.3 мянган төгрөг болж 53,225.8 мянган төгрөгөөр буурсан байгаа нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа санхүүгийн 990.0 мянган төгрөгийн өртөгтэй 2013 оны Аcolous программ ашиглаж байгаа бөгөөд 990.0 мянган төгрөгийн хорогдуулга байгуулан санхүүгийн тайланд тусгасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Чойжин ламын сүм музей нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,074,935.4 мянга, нийт зарлагыг 1,074,935.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, тогтмол зардал, хангамж, бараа материал, томилолтын зардлыг нийт 262,413.6 мянган төгрөгөөр бууруулж, 812,521.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь түрээсийн зардлын төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй илүү тооцсонтой холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 71,361.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хоёр хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 883,883.4 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 849,246.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 126.205.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 849,246.9 мянган төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 34,635.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702 Соёл урлаг	883,883.4	849,247.9	34,635.5	96.2%
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	650,097.6	643,633.8	6,463.8	99.0%
3	80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	6,000.0	6,000.0	-	100.0%
4	80219 Харуул, хамгаалалтын зардал	70,626.8	70,626.8	-	100.0%
5	80802 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,412.8	19,412.8	-	100.0%
6	81569 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	10,589.5	10,589.5	-	100.0%
7	81855 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	127,156.7	98,985.0	28,171.7	77.8%

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар: Эрх бүхий дээд байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу тухайн байгууллагын ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийж, бүтцийг шинэчлэн зохион байгуулсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар 20 орон тоотой байснаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 14 орон тоотой 9 хувиар бууруулсан байна.

Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар: Тайлант онд бүтэц орон тоог 20 хүнээр төлөвлөн хоол, унааны хөнгөлөлтөд 42,875.9 мянган төгрөгийг баталсан,

гүйцэтгэлээр дунджаар 18 бүтэц орон тоонд 32,160.0 мянган төгрөгийг зарцуулсан. Чойжин ламын сүм музейн захирлын 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн Б/06 тоот тушаалаар хоолны мөнгийг 1 өдрийн 8.0 мянган төгрөгөөр, тайлант жилийн хугацаанд унааны хөнгөлөлтөд 1 өдрийн 1.5 мянган төгрөгөөр тогтоон тайлант оны цалинд тооцон олгосон байна.

Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны талаар: Тайлант онд гадаад албан томилолт, арга хэмжээнд нийт 34,023.1 мянган төгрөгийн зардал гаргасан бөгөөд уг зардал нь Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин сайдын яам, Солонгосын соёлын нийгэмлэгтэй хамтран 2025 оны 5 дугаар сарын 20-ноос 26-ны өдрүүдэд БНСУ-ын “Гуружи” галерейд зохион байгуулсан “Мандала” үзэсгэлэнтэй холбоотой байна.

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны талаар: Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зориулж "Соёлын өв ба аялал жуулчлал "Эрдэм шинжилгээний хурал", "Хөтөч тайлбарлагч бэлтгэх, чадавхжуулах сургалт"-ыг зохион байгуулж, Нэмэлт санхүүжилтийн зарцуулах эрх нээгдээгүй тул холбогдох зардлыг өглөгөөр бүртгэн санхүүгийн тайланд тусгасан байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны талаар: Нийгмийн хариуцлагын хүрээнд E TV телевиз нь байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан рекламн шторк, дүрс бичлэгийг үнэ төлбөргүйгээр өөрийн нэвтрүүлгийн хоорондын эфирээр цацаж байршуулсан байна.

Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын судалгааны талаар: Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 240,439.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, хангамж, бараа материалын зардалд 24,059.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 41,941.9 мянга, бараа ажил үйлчилгээний зардалд 46,732.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Чойжин ламын сүм музей нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 95,100.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 12 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөн баталж, гүйцэтгэлээр 44,700.0 мянган төгрөгийн бараа болон засварын ажлыг шууд худалдан авч, 50,400.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын үйлчилгээг сонгон шалгаруулалтаар зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүртгэл хөтлөлт, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эс Жи Эм Ди аудит ХХК-ийн ахлах аудитор О.Алтанцэцэг, аудитын шинжээч Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер М.Бямбажаргал, аудитын менежер Б.Оюунцэцэг, захирал Д.Насанжаргал нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Нямсүрэн, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,115,979,2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,159.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь тэтгэвэрт гарсан ажилчдад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг бусад тэтгэмжтэй давхардуулан олгоогүй, байгууллагын хөрөнгөөр гар утасны төлбөр төлөөгүй, хэвлэл захиалаагүй байгаа хэдий ч үйл ажиллагаанд ашиглагдах компьютерыг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 309,621.1 мянган төгрөгийн зөрчлөөс 224,643.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 64,977.6 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 146,552,800 төгрөгийн 5 гүйлгээг хугацаа хоцроож, 12,000,000 төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 232,643.5 мянган төгрөгийн 11 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1-т "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ. Үүнд:

Илрүүлэлт 1: Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулж хэвлүүлсэн 8,909.2 мянган төгрөгийн өртөг бүхий номыг шаардах хуудсаар зарлагадсан, захирлын тушаалаар 37,566.9 мянган төгрөгийн өртөгтэй ном, эмхэтгэлийг бусдад үнэ төлбөргүй өгсөн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Олон нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор төсвийн хөрөнгөөр хэвлүүлсэн ном, эмхэтгэлийг бусдад үнэ төлбөргүй түгээдэг асуудлыг хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, үр дүнг тооцож ажиллах -

Илрүүлэлт 2: Хувь хүмүүстэй ажил гүйцэтгэх гэрээгээр 14,211.0 мянган төгрөг олгож, 3,410.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй. Энэ нь "Нийгмийн даатгалын ерөнхий хууль"-ийн 19.1-т Даатгуулагч ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг хамааруулна. 19.1.2-т " Иргэний хуулийн 343,359 зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээ тохирсон цалин хөлс" гэсэн заалтад нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагаатай холбоотой хувь хүмүүстэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын хөлс олгохдоо холбогдох хууль, журмын дагуу татвар, нийгмийн даатгалын шимтгэл суутгаж, тайлагнаж хэвших.

Илрүүлэлт 3: Тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан талаарх нотлох баримтыг ирүүлээгүй оролцогчийг шалгаруулж, гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.9-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж: Тендер шалгаруулалтын баримт материалыг бүрэн хангаж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.9-д заасныг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт 4: Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 цомцог гэрүүдийг Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын дагуу түрээслүүлээгүй, бартерын гэрээ байгуулан, ашиглалтын зардлыг төсвөөс төлсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолтой тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 цомцог гэрүүдийг Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын дагуу түрээслүүлэх, бартерын гэрээ байгуулахгүй байх, ашиглалтын зардлыг түрээсийн орлогоос төлөх, үр ашигтай ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт 5: Тайлант онд төвлөрүүлж, зарцуулсан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төлөвлөөгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг", 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн 5.7-д "Орлогыг төлөвлөгөөгүй төсөвт байгууллагад үндсэн үйл ажиллагааны нэмэлт төсвийг зарцуулах эрх олгохгүй" гэсэн заасантай тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагааны жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны III улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө данстуудад горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 2,500.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчилд 112,385.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 10,008.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	112,385.3	2	112,385.3	100.0
Зөвлөмж	1	10,008.4	1	10,008.4	100.0
Нийт дүн	3	122,393.7	3	122,393.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/З тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу санхүүгийн программ хангамжид тайлангийн маягт, заавартай тулган нийцүүлсэн эсэхийг үзэх
2. Агуулахад их хэмжээний үлдэгдэлтэй байгаа ном эмхэтгэл асуудлыг нягтлах
3. Үндсэн үйл ажиллагааны орлого нь И-баримтыг мэдээлэлтэй тулгах зэрэг асуудлуудыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 125,830.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 125,830.6 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 125,830.6 мянган төгрөгийг Сангийн яам татан төвлөрүүлсэн, санхүүгийн байдлын тайланд байгууллагаас авах авлагаар тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.", 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэж заасантай тус тус нийцээгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1 залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11,159.8 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 910,353.6 мянган төгрөгийн орлого болон зарлагын дүнтэй төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэсэн боловч нийт дүнгээр, хөтөлбөрөөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга зэргийг иж бүрэн тайлагнаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.1-т "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/", 54.5.3-д "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл", 54.5.4-т хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/", 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүний дагуу гаргах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 125,830.6 мянган төгрөгийг Сангийн яам татан төвлөрүүлсэн, санхүүгийн байдлын тайланд байгууллагаас авах авлагаар тайлагнаагүй.	1	125,830.6	1	125,830.6	-	-	1	125,830.6	-	-	-	-
	Дүн	1	125,830.6	1	125,830.6	-	-	1	125,830.6	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Төлбөрийн акт	Тоо	Албан шаардлага		
						Тоо	Дүн	
1	Тайлант онд 910,353.6 мянган төгрөгийн орлого болон зарлагын дүнтэй төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэсэн боловч нийт дүнгээр, хөтөлбөрөөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга зэргийг иж бүрэн тайлагнаагүй.	1	-	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	-	1	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Албан шаардлага	Тоо	Дүн	
						Тоо	Дүн

/мянган төгрөгөөр/

Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 146,552.8 мянган төгрөгийн 5 гүйлгээг хугацаа хоцроож, 12,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 232,643.5 мянган төгрөгийн 11 гүйлгээг мэдээлээгүй.	1	244,643.5	1	244,643.5	-
	Дүн	1	244,643.5	1	244,643.5	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулж хэвлүүлсэн 8,909.2 мянган төгрөгийн өртөг бүхий номыг шаардах хуудсаар зарлагадсан, захирлын тушаалаар 37,566.9 мянган төгрөгийн өртөгтэй ном.эмхэтгэлийг бусад үнэ төлбөргүй өгсөн.	1	37,566.9	-	-	37,566.9
2	Хувь хүмүүстэй ажил гүйцэтгэх гэрээгээр 14,211.0 мянган төгрөг олгож, 3,410.6 мянган төгрөгийн НДШ суутгаж тайлагнаагүй.	1	3,410.6	-	-	3,410.6
3	Тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан эсэх нотлох баримтыг ирүүлээгүй оролцогчийг шалгаруулж гэрээ байгуулсан.	1	24,000.0	-	-	24,000.0
4	Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 цомцог гэрүүдийг Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын дагуу түрээслүүлээгүй, бартерын гэрээ байгуулан, ашиглалтын зардлыг төсвөөс төлсөн.	1	-	-	-	-
5	Тайлант онд төвлөрүүлж, зарцуулсан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого болох 91,282.8 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө байхгүй.	1	-	-	-	-
	Дүн	5	64,977.6	-	-	64,977.6
	Нийт дүн	6	309,621.1	1	244,643.6	64,977.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 436/АО/50/22

Улаанбаатар хот

САГ-2026/313/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Чойжин ламын сүм музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 146,552,800.00 (Нэг зуун дөчин зургаан сая таван зуун тавин хоёр мянга найман зуу) төгрөгийн 5 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, зарлагын 232,643,460.11 (Хоёр зуун гучин хоёр сая зургаан зуун дөчин гурван мянга дөрвөн зуун жаран төгрөг арван нэг) төгрөгийн 11 гүйлгээ, орлогын 12,000,000.00 (Арван хоёр сая) төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чойжин ламын сүм музейн захирал (Д.Мөнхчулуун), ерөнхий нягтлан бодогч (Д.Батжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

(Handwritten signature)
9005709
ATA16087
9025081411

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0123 SAG-75.Docx

1526180938